

2017 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 11-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН  
УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

№	Товч агуулга	Хэрэгжилт
1	Нийслэлийн 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж, өвлийн их ачааллын үед иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарах, инженер хангамжийн байгууллагуудыг энэ сарын 15-ны дотор ажлуудаа бүрэн дуусгах, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай бригадыг бэлэн байлгах. /Захирагчийн ажлын алба, Дүүргүүд, Хэрэгжүүлэгч агентлагууд, Захирагчийн харьяа байгууллагууд/	Байгууллагын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө гарган зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авсан ба холбогдох тариаланч, малчид, фермерүүд, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр зөвлөгөө өгч мөн цаг агаарын урьдчилсан мэдээг цаг тухай бүрт малчид, тариаланчдад хүргэн ажиллаж байна.
2	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дарга нар Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгасан саналаа энэ долоо хоногтоо багтаж НЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтэст тулгаж дуусгах. /Хэрэгжүүлэгч агентлагууд/	Нийслэлийн ЗДТГ-ын Бодлого төлөвлөлтийн салбар хариуцсан мэргэжилтэн Ариунцэцэг болон тухайн хэлтсийн дарга мэргэжилтнүүдэд Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд оруулах саналыг 2017 оны 09 сарын 20-ны өдөр тулгалт хийж эцэслэв.
3	Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа Архив, албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийн хөгжүүлэлтийг сайжруулах, байгууллагууд албан бичиг шийдвэрлэлтийн хугацаанд анхаарч, хяналт тавьж ажиллах. /Нийслэлийн Архивын газар, Нутгийн захиргааны нийт байгууллагууд/	Монгол улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам болон Нийслэлийн Засаг даргын А/252 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам"-ын хэрэгжилтийг ханган албан хэрэг хөтлөлтийн системд бүртгэгдсэн нийт бичгийн эргэлт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. 2017 оны эхний хагас жилийн албан бичгийн шийдвэрлэлтийн тайланг гарган хэлтсүүдэд хүргүүлэн албан хаагчдад албан бичгийн шийдвэрлэлтийн тэмдэглэлд хэрхэн шийдвэрлэсэн талаарх товч мэдээллийг хууль зүйн үндэслэлтэй, тодорхой тусгаж, иргэн, хуулийн этгээдэд хариуг тухай бүр мэдэгдэж байх талаар анхаарч, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.